



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025. оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7,1, 55 дугаар зүйлийн 55,3, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,4, Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" 1 дүгээр хавсралт "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", Улсын их хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын 4.2.5-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн "Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хэрэгжилтийн тайланг жил бүр гарган, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Заахиргаа, хүний нөөцийн албаны дарга (Ц.Одонтуяа)-д даалгасугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт тавьж ажиллахыг Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга (Б.Бадамням)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ӨНӨРСАЙХАН



Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн
даргын оны дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨР /2025-2028/**

Нэг. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

- 1.1. Хөтөлбөрийн зорилго
- 1.2. Эрх зүйн үндэслэл
- 1.3. Хэрэгцээ шаардлага

Хоёр. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилт

- 2.1. Тэргүүлэх чиглэл
- 2.2. Өнөөгийн байдал

Гурав. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа

- 3.1. Ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох
- 3.2. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх
- 3.3. Эрүүл аюулгүй таатай ажлын байрыг бий болгох
- 3.4. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах

Дөрөв. Хөтөлбөрийн зохион байгуулалт

- 4.1. Хөтөлбөрийн үе шатууд
- 4.2. Хөтөлбөрийн санхүүжилт
- 4.3. Хөтөлбөрийн үр дүн, хяналт үнэлгээ

НЭГ. АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Байгууллагын алсын хараа:

Олон улсын стандартыг хэрэгжүүлэгч эмнэлэг болно.

1.2. Эрхэм зорилго:

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн, нотолгоонд суурилсан, анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, чанартай аюулгүй тусламж үйлчилгээтэй, манлайлагч эмнэлэг болно.

1.3. Байгууллагын үнэт зүйл:

С-Сэтгэл ханамж

Х-Хариуцлагатай байдал

Д-Дэвшилтэт технологи

Э-Ээлтэй орчин

М-Мэргэшсэн баг

Т-Түүхэн замнал

1.4. Хөтөлбөрийн зорилго:

Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрны аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлэх, ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд оршино.

1.5. Эрх зүйн үндэслэл:

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д төрийн албанд "Мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг баримтална" гэж заасан. Мөн тус хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дах заалтад "Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ" гэж заасан. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" 1 дүгээр хавсралт "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", Улсын их хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын 4.2.5 дах хэсгийг тус тус үндэслэл болгов.

1.6. Хэрэгцээ шаардлага:

Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нь байгууллагын нэн чухал асуудлын нэг юм. Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх нь байгууллагын ажилтнуудын ажиллах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, эерэг хамт олон бүрдүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй тогтвортой байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

2.1 Тэргүүлэх чиглэл

2.1.1 Цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох

2.1.2 Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх

2.1.3 Эрүүл аюулгүй таатай ажлын байрыг бий болгох

2.1.4 Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах

2.1 Ажилтнуудын нийгмийн байдал:

Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв нь батлагдсан нийт 447 орон тоотойгоос 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 351 ажилтан ажиллаж байгаагаас их эмч 91, сувилагч 90, эмнэлгийн мэргэжилтэн 14, тусгай мэргэжилтэн 34, бусад ажилтан 122 байна. Үүнээс эрэгтэй ажилтан 52 буюу 14.8 хувь, эмэгтэй ажилтан 299 буюу 85.2 хувь байна.

График 1. Албан тушаал




Нийт ажилтнуудын ажилласан жил, туршлагыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Ажилласан жил

№	Ажилласан жил	Тухайн байгууллагад	
		Тоо	Хувь
1	4 хүртэл жил	119	44.9%
2	5-9 жил	58	21.9%
3	10-15 жил	39	14.7%
4	16-аас дээш жил	49	18.5%

Нийгмийн асуудлын судалгаанд хамрагдсан ажилтнуудын 69.1% буюу 183 ажилтан гэрлэсэн, 5.3% буюу 14 ажилтан хамтран амьдрагчтай, 13.2% буюу 35 ажилтан өрх толгойлсон, 12.7% буюу 21 ажилтан ганц бие, гэрлээгүй ажилтнууд байна.

График 2. Гэр бүлийн байдал



Амьдарч буй орон сууцны нөхцөл: Судалгаанд оролцогчдын 92 буюу 34.7% нь орон сууцтай /өөрийн эзэмшлийн болон зээлтэй/ бол 55 буюу 20.8% нь өөрийн эзэмшлийн хашаа, байшин гэрт амьдардаг.

Харин 67 буюу 25.3% нь түрээсийн орон сууц, хашаа, байшин гэрт амьдардаг бол 50 буюу 18.9% нь бусдын гэрт /өөрийн хадам аав ээжийнд, ах дүүгийн, хүүхдийндээ/ амьдарч байна.

Хүснэгт 2. Орон сууцны нөхцөл

№	Орон сууцны нөхцөл	Ажилтны тоо	Эзлэх хувь
1	Өөрийн эзэмшлийн орон сууцтай / зээлгүй/	20	7.5%
2	Орон сууцтай /Ипотекийн зээлтэй/	49	18.5%
3	Орон сууцтай /Банкны болон хувь лизингийн зээлтэй/	7	2.6%
4	Орон сууцтай /Түрээслээд өмчлөх зээлтэй/	16	6%
5	Өөрийн эзэмшлийн хашаа, байшин	35	13.2%
6	Өөрийн эзэмшлийн хашаа, гэр	20	7.5%
7	Өөрийн эзэмшлийн гэртэй, газар түрээсэлдэг	11	4.2%
8	Өөрийн эзэмшлийн газартай, гэр түрээсэлдэг	1	0.4%
9	Түрээсийн орон сууц	39	14.7%
10	Түрээсийн хашаа, байшин	6	2.7%
11	Түрээсийн хашаа, гэр	10	3.8%
12	Бусдын гэрт амьдардаг	50	18.9%
	Нийт	265	100%


Түрээсийн орон сууц болон бусдын гэрт амьдарч байгаа ажилтнуудыг ажилласан жилээр харьцуулж үзвэл:

Хүснэгт 3. Орон сууцны нөхцөл

Ажилласан жил	Орон сууцны нөхцөл	Тоо	Хувь
Орон сууц болон хашаа байшин, гэр түрээсэлдэг	2 жил хүртэл	14	20.9%
	2-5 жил хүртэл	20	29.9%
	5-9 жил хүртэл	17	25.3%
	10-16 жил хүртэл	14	20.9%
	16-аас дээш жил	2	3%
Бусдын гэрт /өөрийн хадам аав ээжийнд, ах дүүгийн, хүүхдийндээ/ амьдардаг	2 жил хүртэл	17	36.2%
	2-5 жил хүртэл	11	23.4%
	5-9 жил хүртэл	8	17%
	10-16 жил хүртэл	4	8.5%
	16-аас дээш жил	7	14.9%

Зээл болон зээлийн төрөл: Судалгаанд оролцогчдын 245 буюу 92.5% нь зээлтэй, 20 буюу 7.5% нь зээлгүй байна. Үүнээс хамгийн их буюу 188 ажилтан цалингийн зээлтэй, 80 ажилтан хэрэглээний зээлтэй, 69 ажилтан ББСБ-ын зээлтэй байна.

График 3. Зээлийн төрөл




Хүүхдийн тоо болон насны бүлгийг авч үзвэл: Судалгаанд оролцогчдын 226 буюу 85.3% нь хүүхэдтэй, 39 буюу 14.7% нь хүүхэдгүй байгаа бөгөөд дундаж хүүхдийн тоо 2.4 байна.

Хүснэгт 4. Хүүхдийн тоо, насны үзүүлэлт

Үзүүлэлт	Ангилал	Ажилтны тоо	Эзлэх хувь
Хүүхдийн тоо	1 хүүхэдтэй	45	19.9%
	2 хүүхэдтэй	94	42%
	3 хүүхэдтэй	45	19.9%
	4 хүүхэдтэй	35	15.5%
	5 хүүхэдтэй	5	2.2%
	6 хүүхэдтэй	1	0.4%
Нийт		226	100%

Хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэр тогтоолгосон нийт 26 ажилтан байгаагаас тулгуур эрхтний бэрхшээлтэй 4, харааны бэрхшээлтэй 3, бусад өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдсан 19 ажилтан байна.

График 4. Хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл, хувь



Гурав. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа

3.1. Цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох

3.1.1. Урамшуулал, цалин хөлсний тогтолцоог дотоодын нөөц бололцоо, эрх зүйн хүрээнд шинэчлэх, боловсронгуй болгох

3.1.2. Мөнгөн болон мөнгөн бус урамшууллын шинэлэг тогтолцоог судалж, нэвтрүүлэх

3.2. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх

3.2.1. Ажилтнуудын нийгмийн асуудлын судалгааг авч, судалгаанд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөө боловсруулах

3.2.2. Ажилтнуудыг Нийслэлийн орон сууцны корпорацаас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууц хөтөлбөрт хамруулах саналыг холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хамруулах

3.2.3. Ажилтнуудын хүүхдийн өдөр өнжүүлэх ангийг байгууллага дээрээ ажиллуулах нөхцөл боломжийг судлан, хэрэгжүүлэх

3.2.4. Ажилтнуудын хүүхдийг цэцэрлэгт хамруулах талаар байгууллагын зүгээс холбогдох байгууллага, албан тушаалтанд санал тавьж, дэмжлэг үзүүлэх

3.2.5. Ажилтнуудыг болзошгүй гамшиг ослын үед зайнаас ажиллах нөхцөл боломжийг судалж, хэрэгжүүлэх

3.2.6. Урлаг спортын тэмцээн уралдаан, явган аялал, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын тэмдэглэлт баярын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах

3.3 Эрүүл, аюулгүй, тайтай ажлын байрыг бий болгох

3.3.1. Ажлын байрны үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үнэлгээний дүнд үндэслэн ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах

3.3.2. Ажлын байрны аюулгүй орчин бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тохижилт, засварын ажлыг үе шаттайгаар хийх, үр дүнг тооцох

3.3.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр жил бүр сургалт тогтмол зохион байгуулах

3.3.4. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчний судалгааг гаргаж, шалтгааныг судлан мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах

3.3.5. Ажлын байранд алжаал тайлах, дасгал хөдөлгөөн хийх чийрэгжүүлэлтийн өрөөг тохижуулах

3.4. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах

3.4.1. Эмч, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор, ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмчийг томилон ажиллуулах

3.4.2. Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд нэгээс дээш удаа хамруулах

3.4.3. Эмч, ажилтнуудын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, хөдөлмөрийн чадвар түр алдалтыг судлан, бууруулах бодлого боловсруулан хэрэгжүүлэх

3.4.4. Ажилтнуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах, хүнд өвчнөөр өвдсөн болон урт хугацаанд өвчтэй байгаа ажилтнуудад тэтгэмж олгох

3.4.5. Ажилтнуудыг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтад хамруулах

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжих хугацаа, үе шат

1-р үе шат: 2025 онд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

2-р үе шат: 2026 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх

3-р үе шат: 2027 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх

4-р үе шат: 2028 онд хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Улсын төсөв
- Байгууллагын төсөв
- УИХ-ын гишүүдийн дэмжлэг, хөрөнгө оруулалт
- Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт
- Нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дэмжлэг, хөрөнгө оруулалт
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын дэмжлэг, хөрөнгө оруулалт

Зургаа. Хөтөлбөрийн үр, дүн, хяналт үнэлгээ

6.1. Орон сууцны нөхцөлөө сайжруулсан ажилтнуудын тоо, хувь

6.2. Гэр олгосон ажилтнуудын тоо, хувь

- 6.3. Урлаг спорт, мэргэжлийн тэмцээн уралдаан өдөрлөг зохион байгуулсан тоо, хамрагдсан ажилтнуудын хувь
- 6.4. Ажлын байрны нөхцөлийг сайжруулж, тохижилт засварын ажилд зарцуулсан хөрөнгө
- 6.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, ажилтнуудын хамрагдалтын хувь
- 6.6. Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт хамрагдалтын хувь
- 6.7. Ажилтнуудын эрүүлжилтийн хувь